

“БАЯНХОНГОР-ЭРЧИМ ХҮЧ” ЦАХИЛГААН ТҮГЭЭХ ХЯЗГААРЛАГДМАЛ  
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ

ТҮҮХЭН ЗАМНАЛ

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1965 оны 5-р сарын 12-ны өдрийн 154 тоот тогтоолд аймгуудын Эрчим хүчний газрыг 1965-1966 онд багтаан байгуулахаар заасны дагуу 1966 оны 4 дүгээр сарын 01-нд Баянхонгор аймгийн төвд Эрчим хүчний үйлдвэр байгуулагдсан байна.

КОМПАНИЙН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Компани нь ТУЗ-11 гишүүнтэй, Захиргаа аж ахуй хэсэг, Цахилгаан шугам сүлжээ шуурхай үйлчилгээний алба, Хэрэглэгчдэд үйлчлэх төв гэсэн 1 хэсэг хоёр албатай 94 хүний бүрэлдэхүүнтэйгээр 21,561,252,139.17 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, Өөрийн хөрөнгийн хэмжээ 1,426737,372.97, Тайлант үеийн татварын дараах ашиг-222,381,718.92, Татвар төлөлт-1,175,118,300 төгрөг төлөгдсөн байна. Цахилгаан түгээх, цахилгаанаар зохицуулалтай хангах, тоолуур хэмжих хэрэгсэл, тусгай зөвшөөрлүүдийн хүрээнд Баянхонгор аймгийн төв болон ойролцоох Өлзийт, Эрдэнэцогт сумдыг 6кВ-ын 79.7 км, Шаргалжуут рашаан сувлал тосгон, Заг Гурванбулаг, Жаргалант, сумдын 10 кВ-ын 151,6 км, Баян Овоо, Галуут, Баацагаан, Хүрээмарал, Баянбулаг сумдыг 15 кВ-ын 347 км, Бөмбөгөр, Бууцагаан, Заг сумдыг 35 кВ-ын 302,3 км Цахилгаан дамжуулах агаарын агаарын шугамаар тэжээж нийт 880,6 км ЦДАШ, 202 дэд станц трансформатораар дамжуулан Аж ахуй нэгж албан байгуулага, Ахуйн хэрэглэгчид нийт 13878 хэрэглэгчдийг тасралтгүй найдвартай цахилгаан эрчим хүчээр ханган ажиллаж байна.

2022 ОНД ДАРААХ ЗОРИЛГО ЗОРИЛТУУДЫГ ДЭВШҮҮЛЖ АЖИЛЛАА

- 1.Хэрэглэгчдээ стандартын шаардлага хангасан Цахилгаан эрчим хүчээр тасралтгүй, хангах эрхэм үүргээ биелүүлэх
- 2.Техникийн болон техникийн бус алдагдлыг төлөвлөсөн хэмжээнээсээ сар бүр бууруулж ажиллах
- 3.Үргүй зардлыг багасгаж балансыг ашигтай гаргах боломж, нөхцөлийг бүрдүүлж, өр авалгагүй гаргах

4.Төсөл хөтөлбөр хөрөнгө оруулалтын ажлуудад оролцож үйл ажиллагааны бус орлогыг нэмэгдүүлэх

5.Хамт олноороо ёс зүй, сахилга хариуцлага, дэг журмыг баримтлан ажиллах “Тэргүүний компани” болох

6.Компанийн дотоод нөөц боломжид тулгуурлан бүтээн байгуулалтын ажлыг өрнүүлэх

7.ХХАА-ны дүрэм журмыг биелүүлж “Осол авааргүй хамт олон” болох